



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/347

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан журмын 2.1.1, аймгийн Онцгой комиссын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 07 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гоц халдварт тарваган тахал өвчний улмаас хязгаарлалт тогтоосон Жаргалант, Цэцэг сумдын хамгаалалт, зохицуулалтанд ажиллах аймгийн Цагдаагийн газрын албан хаагчдын 6 хоногийн хоолны зардалд 1644.0 мянган төгрөг /нэг сая зургаан зуун дөчин дөрвөн мянган/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2. Тус арга хэмжээнд зарцуулах 1644.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны
07 дугаар сарын 02-ны өдрийн
А/347 дугаар захиармжийн хавсралт



ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНИЙ УЛМААС ХЯЗГААРЛАЛТ БҮХИЙ
ЖАРГАЛАНТ, ЦЭЦЭГ СУМДАД АЖИЛЛАХ ЦАГДААГИЙН
АЛБАН ХААГЧДЫН ХАМГААЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Д/д	үзүүлэлт	Ажиллах хоног	Хэмжих нэгж	Тоо	Нэгж үнэ /төгрөг	Нийт үнэ /мянган төгрөг/
1.	Мах	6	кг	15	12000.00	1080.0
2.	Гурил		кг	10	2000.00	120.0
3.	Будаа		кг	10	2500.00	150.0
4.	Гоймон		кг	2	7500.00	90.0
5.	Хүнсний ногоо		кг	10	2500.00	150.0
6.	Ургамлын тос		ш	2	4500.00	54.0
Дүн						1644.0

-оОо-